

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар:17/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын заланд 2017.04.05-ны өдрийн 16.00 цагт болов.

“Хүрд “ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга Ж.Дүгэржавыг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Ж.Дүгэржавын танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 129,892.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 10 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 96 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Эрдэнээ, Д.Мадгаа, Б.Мөнхбат, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Г.Алтансүх, Б.Бат-Эрдэнэ, Л.Цэрэндондог нарын 10 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, 2017 оны удирдлагын зардлыг батлах

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг “Хүрд” компанийн захирал Б.Энхжаргал уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2016 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардалтай та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан байгаа, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж- Компанийн 2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлттэй танилцлаа. 2016 оны үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилт биелж, 4,3 тэрбум төгрөгийн борлуулалт, 929,1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.Барилга угсралтын ажлын хувьд 336 сая төгрөг, түрээсийн ашиг 72,6 сая, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг 626,8 сая төгрөг, компанийн хэмжээнд ашигт ажиллагааны түвшин 24% байна.

Ногдол ашигт нэгж хувьцаанд 755 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Ногдол ашгийн хэмжээ урьд оныхоос бараг 3 дахин нэмэгдсэнд хувьцаа эзэмшигчийн хувьд баяртай байна. Удирдлагын зардлаас 38,0 сая төгрөг хэмнэсэн байна. Яг ямар зардлаас хэмнэсэнээ илтгэсэнгүй. ТУЗ-ийн дүгнэлтээс харахад мэргэжилтэй ажилтнуудыг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд 9 удаагийн сургалтад 7,33 сая төгрөг зарцуулсан байна. Бизнес

төлөвлөгөөний борлуулалтын орлого бага зэрэг тасарсан ч ашгийн хэмжээ нэмэгдсэн байна.

Ажилтнуудын дундаж цалин буурсныг барилга угсралтын ажил буурсантай холбож ойлголоо. Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ.

Барилга угсралтын ажлыг гүйцэтгээд олж авч чадаагүй байгаа 1,0 тэрбум төгрөгийг олж авах талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байгаа юм байна. Орон сууц барих асуудлыг дэмжиж байна.

“Хүрд-Нарлаг” ХХК алдагдалтай ажилласныг анхаарах.

Төмөр хийцийн цех, бетон эдлэлийн цехийн бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилтнаар хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Орон сууц ашиглалтын талаар асуух зүйл байна. Орон сууц ашиглалтын контор ус дулааны ашиглалтыг хариуцна гэлээ. Цахилгааны ашиглалтыг хариуцах уу. Орон сууц ашиглалтын талаар тайлбар өгнө үү.

Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах саналтай байна.

Захирал Б.Энхжаргал: Орон сууц ашиглалтын контор цахилгааны ашиглалтыг мөн хариуцна. Орон сууц ашиглалтын үйл ажиллагааг 2017 оны 01-р сараас эхэлж байгаа. УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК, УСУГ-тай ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байгаа. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваад байна. Одоо Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авна. Орон сууц ашиглалтын конторын үйл ажиллагааг одоогоор компанийн бүрэлдэхүүнд, тусдаа данстайгаар явуулж байгаа. Цаашдаа бие даасан охин компани болгоно. Одоогоор конторын харьяанд 31 орон сууц, 70 орчим аж ахуйн нэгж байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Энэ жил орон сууц барина гэж байна. Барилгын материалын үнэ өсөөд байгаа юм биш үү. Орон сууцаа ямар хөрөнгөөр, ямар компаниар бариулж байгаа вэ? Орон сууцны 1м²-ийн өртөг хэдэн төгрөг байгаа вэ. Засгийн газрын бонд худалдаж авах талаар Та бүхэн ямар бодолтой байна. Засгийн газрын бондын хүү 18%, татвараас чөлөөлөгдөхөөр тусгагдсан байгаа.

ТУЗ-ийн дарга: Б.Мөнхбат: Засгийн газрын бондын талаар бид судалж байгаа. Барилгын материалын үнийн өсөлт харьцангуй гайгүй байгаа. Харин гадаад зах зээлд төмрийн үнэ нэлээд өсч байна.

Захирал Б.Энхжаргал: Орон сууцыг өөрийн хөрөнгөөр, өөрсдийн хүчээр барьж байгаа.Бетон зуурмагаа өөрийн Бетон эдлэлийн үйлдвэрт үйлдвэрлэж байгаа.

Хувьцаа эзэмшигч Л.Цэрэндондог. Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, ашигтай ажилласан байна. Ногдол ашгийн хэмжээ ч нэмэгдсэн байна. Эдийн засаг хүндрэлтэй байгаа 2017 онд ч боломжийн зорилт дэвшүүлсэн байна. “Хүрд Нарлаг” ХХК-ийг ашигтай ажиллуулах талаар ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Засгийн газрын бонд худалдаж авах, материалын худалдаа эрхэлж ашиг олох тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Компанийн бизнес төлөвлөгөөг батлах саналтай байна.

Захирал Б.Энхжаргал:“Хүрд Нарлаг “ ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж “Барилгачин” сувилал болгохоор 2016 онд их засвар хийсэн. Хөдөлмөр халамжийн ерөнхий газраас зарласан “Сувиллын үйл ажиллагаа эрхлэх” тендерт 2017 оны 03-р сарын 22-нд оролцоод хариу хүлээж байгаа. Сувиллын үйл ажиллагаа эхлэх, жигдрүүлэх шаардлагатай байгаа. Сувилал ажиллуулсан тохиолдолд Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх тухай журам"-д хамрагдах эрхтэй болсны дараа л ашигтай ажиллаж эхлэх байх.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: Орон сууц ашиглалтын талаар саналаа хэлэхэд ашиглалтад орсон болон орох орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ, дотор сантехник, цахилгаан, холбооны зургийн иж бүрдлийг бүрдүүлж авах хэрэгтэй гэж бодож байна. Бид цаашид ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхэд зураг зайлшгүй хэрэгтэй. Мөн инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилтан, ойр зуурын материалын нөөцтэй байх хэрэгтэй. 2017оны ноён нурууг босгож чаджээ. Тодорхой төлөвлөсөн ажлууд байна.ТУЗ-ийн тайлан, 2017 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Д.Мадгаа- Миний хувьд ТУЗ-ийн дүгнэлтийг сонслоо. Улс орон эдийн засгийн хямралтай байгаа үед компани яаж ажилласан, 2017 онд хэрхэн ажиллах талаар сонслоо.Энэ илтгэлийг дотор нь ажиллаж байгаа хүний хувьд дэмжиж байна.

Захирал Б.Энхжаргал: Илтгэлийн талаар тайлбар өгье гэж бодож байна.

2016 онд гүйцэтгэсэн 3353,0 сая Барилга угсралтын ажлын 1500,0 сая нь бариаа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн ажлын хөрөнгө байсан. Барилга угсралтын ажлын хувьд 10% ашигтай ажилласан. Төсөвт 15% ашиг тусгагддаг боловч 10%

ашигтай гарсан. 2016 онд барилга угсралтын ажлын хэмжээ эрс багассан. Улс орны эдийн засаг сайн байх үед 500-600 сая төгрөгийн өртөгтэй барилга угсралтын ажлын тендерт 5-6 компани оролцдог байсан бол 2016 онд 100-200 сая төгрөгийн өртөгтэй барилга угсралтын ажлын тендерт 20 гаруй компани оролцож байлаа.

2017 онд улсын төсөвт шинэ барилга угсралтын ажил бараг байхгүй байгаа. Сантехник, цэвэр бохир усны угсралтын ажил бага хэмжээнд байгаа. Компанийн хувьд Сэлбэ дэд төвийн ариутгах татуургын шугамын 730,0 сая төгрөгийн ажил бэлэн байгаа. Гэр хорооллын цахилгаан дамжуулах шугамын ажлын 200,0 сая орчим төгрөгийн өртөгтэй хэд хэдэн тендерт оролцож байна. Барилга угсралтын ажлын өртгийг төлөвлөсөн өртгөөс 30% хүртэл хасч орж байгаа нь ашиг олоход хүндрэлтэй болсныг харуулж байна. Тиймээс 2017 онд компанийн үзүүлэлт буурч гарах байх.

Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжих 4 аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, гаднын хөрөнгөөр санхүүжих 9 аймгийн дулааны станцын тендерт оролцоно.

Өнгөрсөн жил харилцах болон хадгалмжийн хүүгээс 858,0 сая төгрөгийн орлого олж байсан. Энэ бол орон сууц барихын тулд олон жилийн өмнөөс хуримтлуулсан хөрөнгийн хүү юм. Орон сууцаа бариад эхлэхээр энэ хүү багасна. 2017 онд орон сууц барихад ихээхэн хөрөнгө зараад эхлэхээр ашгийн хэмжээ ч багасна. Орон сууцыг 2018 онд ашиглалтад оруулна.

2016 онд 929,1 сая төгрөгийн ашигтай ажилласан тул ногдол ашгийн хэмжээг бараг 3 дахин өсгөсөн байгаа.

Орон сууц ашиглалтын конторын хувьд: бид урьд нь шинэ юм хийж хүлээлгэж өгдөг байсан тул энэ жилээс анх удаа хүний хийсэн юмыг ашиглаж үзэж байна. Хүйтний улиралд ачаалал ихтэй үед айл өрхөөс авсан дулааны мөнгөнөөс ашиг гарахгүй, УБДС ТӨХК-д шилжүүлээд л таарах юм байна. Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд тохиролцоонд хүрч тодорхой хувь нь үлдэх байх.

ТУЗ-ийн дарга Б.Мөнхбат: Үндсэн үйл ажиллагааны ашиг 10% бол бага тоо биш юм. Энэ бол бүх зардал, удирдлагын зардал, газрын төлбөр, ус, дулаан, цахилгаан, холбооны зардлуудын дараах ашиг. 2017 онд барилга угсралтын ажил, ашгийн хэмжээ буурна гэдэгт Захирал Б.Энхжаргалтай санал нэг байна. Та бүхний санал, дүгнэлтийг сонслоо.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2016 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2017 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга Ж.Дүгэржав санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **129,892.0** ширхэг хувьцаа буюу **100 %**.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **129,892.0** ширхэг хувьцаа буюу **100 %**.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
3. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, 2017 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **129,892.0** ширхэг хувьцаа буюу **100 %**.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат уг хэлснээр 17.30 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН:
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХБАТ



ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ГАНТУЯА

